

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Сайн Байцгаана уу,

Өнгөрсөн амралтын өдрүүдэд бид стратеги төлөвлөлтийн сургалт зохион байгуулсан. Энэ сургалтанд оролцсон бүх багш, сурагчид, эцэг эхчүүд, удирдах зөвлөлийн гишүүдэд талархсанаа илэрхийлье. Бид Боловсрол, Боловсон Хүчин, Сургуулийн Хамт Олон, Барилга Байгууламж, Элсэлт гэсэн таван чиглэлээр баг байгуулсан. Эдгээр багууд чиглэл чиглэлийн асуудлаар ирэх таван долоо хоногт ажиллана. Сургалтын мэргэжилтэн 5 сарын 15-16-нд буцаж ирж Үйл Ажиллагааны Төлөвлөгөө боловсруулахад бидэнтэй хамтран ажиллана.

Энэ долоо хоногт манай сургууль дээр Канадын хүүхдийн нэрт зохиолч Margriet Ruurs айлчилж хоёр өдөр манай сурагчидтай уулзалт зохион байгуулж хэрхэн ном бичих талаар ярилцлага хийлээ. Тэрээр номтой нөхөрлөх долоо хоногт зориулсан өдөрлөгийн хүндэт зочноор уригдаж оролцон үг хэлсэн.

Энэ арга хэмжээний үеэр би ангиудаар айлчилж сурагчдад ном уншиж өглөө. Ангиудад очиж сурагчидтай ярилцахад надад сайхан байлаа.

Сурагчдын удирдсан хурал амжилттай болж өнгөрлөө. Хуралд ирж оролцсон бүх эцэг эхчүүддээ болон хурлыг удирдаж явуулсан сурагчиддаа баяр хүргэе. Энэ хурлыг амжилттай зохион байгуулахад бэлтгэсэн багш нартаа баярлалаа.

Та бүхэн хаврын амралтаа ая тухтай сайхан өнгөрүүлээрэй. Сурагчдын хичээл 4 сарын 13-ны Мягмар гарагт эхэлнэ.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Захирал Greg Rayl

ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:

| | |
|---------------------------|--|
| 4 сарын 12-ны Даваа гараг | Хичээл орохгүй, Багш нарын Мэргэжил дээшлүүлэх өдөр |
| 4 сарын 13 | Хаврын амралт дуусч хичээл эхэлнэ |
| 4 сарын 16 | Авбаастнуудын өдөрт оролцогчдыг бүртгэх сүүлийн өдөр |
| 4 сарын 19 | 4-р улирлын Дугуйлангууд эхэлнэ |
| 4 сарын 30 | Дунд сургуулийн сурагчдын жүжигчилсэн тоглолт |

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Сурагчдын удирдсан хурал маш амжилттай болж өнгөрлөө. Дунд сургуулийн нийт эцэг эхчүүдийн 99 % нь хуралд ирж оролцлоо. Хүүхдүүдийнхээ хичээл сурлаганд анхаарал тавьж дэмжлэг үзүүлж хуралд ирж оролцсон бүх эцэг эхчүүддээ баярлалаа.

12-р ангийн сурагчдын 3-р улирлын дүн гарч та бүхний гар дээр очно. Та бүхэн хичээлийн жилээ амжилттай дуусгахад нь тэдэнд туслаарай. Төгсөх ангийн сурагчдын шалгалт 5 сарын эхээр эхэлнэ. Та бүхэн тэдний сурлагын дүнтэй танилцаж ярилцаарай. Бид 4 сарын 13-нд хаврын амралт дууссаны дараа та бүхэнтэй уулзаж ярилцахад бэлэн байна.

Та бүхэн хаврын амралтаа сайхан өнгөрүүлж эрүүл мэнддээ сайн анхаараарай. 4 сарын 13-ны Мягмар гарагт хичээл орно. 12-ны Даваа гарагт багш нар мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдана.

Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann

Номтой Нөхөрлөх 7 Хоног

Өнгөрсөн 2 долоо хоногийн турш манай сурагчдад зориулж Номтой Нөхөрлөх арга хэмжээг зохион байгуулсан Mrs. Moller болон бусад багш нарт баяр хүргэе.

3 сарын 25-нд 4-р ангийн сурагчид Цэцэглэх Ирээдүй төвд зочилж бага ангийн сурагчдад ном уншиж өглөө. Тэдэнтэй хамт 5, 11,12-р ангийн зарим сурагчид бас багш нар нэгдэж энэ төвд зочиллоо. Сурагчдын сэтгэгдлээс:

“Бид зайтай том ангид сурдаг азтай хүүхдүүд юм байна гэж би мэдэж авлаа. Цэцэглэх Ирээдүй төвийн ангиуд манай ангиудаас зай багатай байсан. Бид сайн боловсрол эзэмшиж байгаа азтай хүүхдүүд юм байна гэдгийг бас ойлгосон.”

“Би хүүхдүүдэд зураг яаж будахыг зааж өгсөндөө баяртай байна.”

“Бид нар сайн сургуульд сурч байгаа азтай хүүхдүүд юм байна гэдгийг ойлгосон. Бидний очсон сургууль их жижигхэн сургууль байлаа. Би багачуудад илжиг яаж будахыг зааж өгсөн. Тэр хүүхдүүд их сайн сэтгэж байсан.”

Хэрвээ хүмүүс Монголоор ярьж чадахгүй бол би тэдэнд тусалж чадна гэдгээ мэдсэн. Надад их зугаатай сайхан байсан.”

Би сайн харилцагч, бас эрэлхийлэгч байх зарчмыг хэрэгжүүлсэн. Харин би Монголоор ярьж чадахгүй болохоор миний үүрэг бага байсан.”

4-р ангийн сурагчид:Долгөөн, Kathleen, Буянаа, Ian, Seog Hee

Өдөрлөг

Энэ долоо хоногт манай сургууль дээр Канадын нэрт хүүхдийн зохиолч Margriet Ruurs айлчилж ирсэн. Түүний бичсэн номнуудын нэг нь “Тэмээ миний Номын Санч” нэртэй бөгөөд Монголын хүүхдийн зохиолч Дашдондог Говийн хүүхдүүдэд хэрхэн ном зөөж уншуулж байгаа талаар өгүүлдэг. Бид номтой нөхөрлөх долоо хоногт зориулж өдөрлөг хийж, дуртай номынхоо баатрын дүрээр хувцасласан. Өдөрлөгийн хүндэт зочноор Mrs. Ruurs, зохиолч Дашдондог нар уригдаж оролцсон.

Даваа, Мягмар гарагуудад бүх ангиуд ном хийх талаар болон үлгэр тууж унших цагийгMrs. Ruurs – тай өнгөрүүлсэн. Бага ангийн эцэг эхчүүд та бүхэн хүүхдүүдээсээ Emma-н талаар асуугаарай.

3-р ангийн Tristan: “Өнөөдөр сургууль дээр Margriet ирсэн. Бид ном яаж бичих талаар сурсан. Өөрсдөдөө тохиолдсон явдлыг хэрхэн өгүүллэг болгож бичих талаар би сурсан.”

3-р ангийн Su Hyun “Өнөөдөр би ном яаж бичих талаар сурсан. Би их олон зүйл сурсан. Би өөрийнхөө амьдралын тухай, дуртай газрынхаа тухай хэрхэн бичих талаар сурсан.”

Readathon: Манай сурагчид маш олон хуудас номнууд уншсан. Та бүхэн сурагчдыг ном уншихад дэмжиж тусалсанд баярлалаа.

Номын Солилцоо: Олон сурагчид сольж унших номнууд авчирч амралтаараа унших номнуудаа сонгож авцгаасан.

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Сурагчдын Удирдсан Хурал: Манай сурагчдын удирдсан хуралд ирж оролцсон бүх эцэг эхчүүддээ баярлалаа. Би ангиудаар явж өөрсдийнхөө сурч мэдсэн зүйлийн талаар эцэг эхчүүддээ тайлбарлан ярьж байгаа сурагчдаа хараад бахархаж байлаа. Эцэг эхчүүдийн сэтгэгдлээс:

“Хэмжилт хийх олон аргын талаар охин маань сурсаныг би харлаа. Монгол үндэсний тоглоом яаж тоглохыг охин маань надад зааж өгсөн.”

“Хүү маань ангидаа уншиж бичиж сурч байгаа гэдгийг би мэднэ. Гэхдээ үүнээс гадна өөр олон зүйлийг шамдан суралцаж байгааг нь харлаа.”

“Хүү маань сургууль дээрээ юу сурч байгааг болон сургуульдаа сэтгэл хангалуун байдгийг нь мэдэхэд бидэнд сайхан байлаа.”

“Хуучин Монгол бичгээр нэрээ яаж бичихийг миний охин надад зааж өгсөн.”

“Би хүүхэдтэйгээ хамт олон хэсгээр зочилж хамт байхад сайхан байлаа. Миний сурч байсан үеэс одооны сургалт их өөр хөгжилтэй хэлбэрээр явагддаг болжээ.”

Эрүүл ахуй, Ариун Цэврийн талаар:

Хэд хэдэн хүүхдийн ходоод гэдэс хямарч бөөлжих байдал илэрлээ. Энэ байдлаас сэргийлэх гол үндсэн арга нь гараа сайн угаах явдал юм. Бид энэ талаар сурагчиддаа байнга анхааруулдаг та нар ч бас гэртээ гараа сайтар угаах талаар сурагчдад сануулж байгаарай. Сурагчдын бие сайнгүй бол гэрт

нь байлгаарай.

Charlie and the Chocolate Factory: DVD захиалах хуудсаа төлбөртэй нь хамт ирүүлсэнд баярлалаа. DVD-нүүд амралтын дараа бэлэн болно.

Та бүхэн гэр бүлийнхэнтэйгээ хаврын амралтаа сайхан өнгөрүүлээрэй.

Бага Сургуулийн Эрхлэгч Jan Wiggins

СУРАГЧДЫН ЗӨВЛӨЛӨӨС

Та бүхэн хаврын амралтаараа гадагшаа аялалаар явах бол зочид буудалд буухдаа ариун цэврийн жижиг зүйлс цуглуулж ирэхээ мартваа. Бид Монгол дахь Олон Улсын Хатагтай нарын Нийгэмлэгт урьдын адил цуглуулсан эд зүйлсээ хандивлах болно. Хаврын амралтаас ирэхэд хандивын хайрцаг сургуулийн үүдэнд биднийг хүлээж байх болно.

БИЕЙН ТАМИРЫН ТЭНХМЭЭС

ОУДС-ийн хөл бөмбөгийн баг тамирчид цаг агаарын байдлаас шалтгаалан ихэвчлэн дотор бэлтгэл хийсэн ч тэмцээнд оролцох бэлтгэлээ хангаж дууслаа. Тамирчид энэхүү хүндрэлийг даван гарч цаг агаарын ямар ч нөхцөлд талбай дээр гарч тоглоход бэлэн байгаа гэдэгт би эргэлзэхгүй байна. Энэ жилийн ACAMIS хөл бөмбөгийн тэмцээн 4 сарын 22-24-нд Хятадын Qingdao хотод Shandong ОУСургуулийн шинэ байрны хөл бөмбөгийн талбайд зохиогдоно. Энэ тэмцээн шинээр баригдсан энэ талбайд анх удаагаа зохиогдох гэж байна. ОУДС-ийн тамирчид бас тэдэнд зориулж хийсэн шинэ бэлтгэлийн хувцастайгаа талбайд гарна. Golden Eagles багийхандаа амжилт хүсье.

Охидын баг тамирчид:

Reeza, Rebekah, Jill, Намуун, Catriona, Madeline, Elise, Пүрэвсүрэн, Tiffany, Teresa

Хөвгүүдийн баг тамирчид:

Derryn, Vasek, Jiri, Мишээл, Kristian, Mathias, Ha Ram, Пүрэвбат, Jun Woo, Хишигдорж

Бямба Гарагийн Цэвэрлэгээ

4 сарын 17-ны Бямба гарагт ОУДС Бямба гарагийн цэвэрлэгээ хийж хөл бөмбөгийн талбайн хогийг цэвэрлэж ургасан зэрлэгийг түүнэ. Сурагчид завсарлагаанаар болон биеийн тамирын хичээлийн үеэр тэгш, цэвэр талбай дээр хөл бөмбөг тоглох боломжтой болно. Дунд сургуулийн сурагчид болон эцэг эхчүүдийг энэ арга хэмжээнд сайн дураараа оролцохыг бид бүхэн уриалж байна. Сурагчдын ажилласан цагийг CAS-н цагт тооцох болно.

Бид цэвэрлэгээг 9 цагт эхэлж олон сурагчид, эцэг эхчүүдийн тусламжтайгаар 1 цаг гэхэд талбайг цэвэрлэж дуусгана. Сургууль цэвэрлэгээний материалыг хангаж өгнө. Хүсвэл эцэг эхчүүд, сурагчид та бүхэн өөрсдийн багажаа авчирч болно. Цэвэрлэх талбайг шүүрдэхээс өмнө тоос босгохгүйн тулд услах болно. Сургууль салхины шил, амны хаалт тарааж өгнө. Сурагчид өөрсдийн шил, амны хаалтаа авчирч хэрэглэж болно.

Цэвэрлэгээний туршид уух ус, снэк авах боломжтой. Цэвэрлэгээ дууссаны дараа хөл бөмбөг тоглох боломжтой.

Дугуйлангууд:

4-р улиралд хичээллэх дугуйлангийн талаарх захидлыг өнгөрсөн долоо хоногт сурагчдад өгч явуулсан. Энэ захидлыг аваагүй эцэг эхчүүд байвал хүүхдийнхээ анги удирдсан багшаас аваарай. Сурагчид суралцах дугуйлангийнхаа сонголтыг хийгээд хуудсаа бөглөж ирүүлсэн байх ёстой. Дугуйлангийн хуудсаа ирүүлж амжаагүй сурагчид хаврын амралт дуусмагц хуудсаа ирүүлэх хэрэгтэй. 4-р улирлын дугуйлангууд 4 сарын 19-нээс эхэлнэ.

Биеийн Тамирын Тэнхмийн Эрхлэгч David Ricketts